

2008.01.31

Дугаар16

Зарим компанийн үнэт цаасны зах зээл
дээр явуулах мэргэжлийн үйл ажиллагааг
зогсоох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.5 дугаар заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусгавар болсон “Ажнай инвест” ХХК, “Мөнхөд” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааг зогсоосугай.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан компанийг үнэт цаасны арилжаанд оруулахгүй байхын хамт тэдгээрийн харилцагчдад үзүүлэх үйлчилгээг чирэгдэлгүйгээр эрх бүхий бусад компаниар холболтын данс нээлгэх замаар зохион байгуулж ажиллахыг “МХБ” ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

3. “Масдак” ХХК, “Аргай бэст” ХХК, “Бумбат-Алтай” ХХК, “Эрдэнэст” ХХК, “Дархан брокер” ХХК, “НИКИ” ХХК-д өгсөн шаардлагыг 2008 оны 02 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авах асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ